



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар *А/85*

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 60 дугаар зүйлийн 60.1.21, 60.1.1 дэх заалт, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний 166 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжин тогтвортой хөгжүүлэх зорилгоор "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий ач холбогдол, үр нөлөөг нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулах, залуу үеийг хоршооллын салбарт идэвхжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд аймгийн хэмжээнд "Залуу хоршоологч" төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Э.Мөнх-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн

дарга:

Ж.Энх-Амгалан

Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд:

Г.Ариунчимэг

Хөгжлийн бодлого, төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтсийн
мэргэжилтэн

Э.Хонгорзул

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний
үйлчилгээний газрын дарга

Х.Уртнасан

Гэр бүл, хүүхэд, залуучуудын
хөгжлийн газрын дарга

Б.Энх-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын зөвлөх

Ж.Ганчимэг

Хүнс, хөдөө аж ахуйн газрын хөнгөн
болон жижиг дунд үйлдвэрлэл,

D:\My Documents\ Захирамж-2024

23101070

хоршоо ахуйн үйлчилгээний асуудал
хариуцсан мэргэжилтэн

Б.Цэрэнчимэд Хэнтий аймгийн Хөдөө аж ахуйн
хоршоологчдын холбооны тэргүүн

Ц.Амгаланбаатар Хэнтий аймгийн Үйлдвэрлэлийн
хоршоологчдын холбооны тэргүүн

2.Малчдын хоршооны хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг хагас жил тутам нэгтгэн танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж. Энх-Амгалан)-д, Захирамжын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/129 дүгээр захирамж хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ